
MERIT

Дөрвөн сэнст дроны сургалт

Оронзайн зураглал гаргадаг үнэгүй, нээлттэй эх бүхий программ (FOSS4G) Гео-Академийн сургалтын хөтөлбөр

2018 оны 7 дугаар сарын 18-ны өдөр

http://spatialquerylab.com/foss4g-academy-curriculum/



Газарзүйн мэдээллийн санд зориулсан Орон зайн зураглал гаргадаг үнэгүй, нээлттэй эх бүхий программ (FOSS4G) Гео-Академийн курс бол QGIS, GRASS, Inkscape зэрэгт суурилдаг. Бид нийцтэй байдлыг хангах, онлайн дэмжлэг үзүүлэх үүднээс аймаг, сумдад энэхүү сургалтын хөтөлбөрийг мөрдөхийг зөвлөж байна. Хэрвээ боломжтой бол сургалтын материалуудыг Монгол хэл рүү орчуулна.

ОРОН ЗАЙН ЗУРАГЛАЛ ГАРГАДАГ ҮНЭГҮЙ, НЭЭЛТТЭЙ ЭХ БҮХИЙ ПРОГРАММ (FOSS4G) АКАДЕМИЙН СУРГАЛТЫН ХӨТӨЛБӨР

ОРОН ЗАЙН ЗУРАГЛАЛ ГАРГАДАГ ҮНЭГҮЙ, НЭЭЛТТЭЙ ЭХ БҮХИЙ ПРОГРАММ ГЕО-АКАДЕМИЙН СУРГАЛТЫН ХӨТӨЛБӨР

Гео-Академийн нэрийн өмнөөс Spatial {Query} Lab нь их сургуулийн түвшний Орон зайн зураглал гаргадаг үнэгүй, нээлттэй эх бүхий программын 35**лекц, лабораторийн ажлыг** нээлттэй тавьж, татаж авч болохоор болгосон. Лекц нь тодорхой нэг үйлдвэрлэгчийн бүтээгдэхүүнээс хамааралгүйгээр онол, зарчмыг багцаар нь сургахад голлон анхаарсан. Лабораторийн ажлууд нь QGIS, GRASS, Inkscape зэрэгт тулгуурласан.

Та лекц, лабораторийн ажлуудыг чөлөөтэй татан авч ашиглаж болох бөгөөд “Creative Commons Attribution 3.0” Бүтээгчийн энгийн эх сурвалжийн хагас лицензийн дагуу нийтэд нээлттэй болгосон. Эдгээр лекц, лабораторийн ажлууд нь Гео-орон зайн технологийн чадамжийн загвартай холбоотой бөгөөд бүх лабораторийн ажлууд нь чөлөөтэй, нээлттэй эх үүсвэрээс авч болох газарзүйн мэдээллийн системийн программ (FOSS4G)-д тулгуурласан.

Татан авч, ашиглахад хялбар байлгах үүднээс лекц, лабораторын ажлын агуулгыг энэ цахим хуудаст жагсаав. Бүх лабораторийн ажлуудыг GitHub дээрээс мөн татан авах боломжтой.

Тайлбар: Одоогоор лекц нь интернэтэд зөвхөн HTML хэлбэрээр л байгаа. Татан авч болохуйц файлууд удахгүй тавигдана.

GST 101 – Гео-орон зайн технологи (QGIS)-ийн танилцуулга - QGIS 2.8 хувилбарт тохируулан шинэчилсэн – **Лекцүүдтэй!**

GST 102 – Орон зайн дүн шинжилгээ (QGIS) - QGIS 2.8 хувилбарт тохируулан шинэчилсэн – **Лекцүүдтэй!**

GST 103 – Мэдээлэл олж авах, удирдах (QGIS) - QGIS 2.8 хувилбарт тохируулан шинэчилсэн – **Лекцүүдтэй!**

GST 104 – Зурагзүйн дизайн (QGIS, Inkscape) - QGIS 2.8 хувилбарт тохируулан шинэчилсэн – **Лекцүүдтэй!**

GST 105 – Зайнаас тандан судлах үйл ажиллагааны үндэс (QGIS, Inkscape) - QGIS 2.8 болон GRASS 6.4.3 хувилбарт тохируулан шинэчилсэн.

Боловсруулсан зохиогчид

Анхны материалуудыг боловсруулах ажлыг Хөдөлмөрийн яам (ХЯ)-наас санхүүжүүлсэн. Худалдааг Тохируулах Туслалцааны Олон Нийтийн Коллеж, Карьер Сургалтын Төв (ХТТОНКЗСТ)-ийн №ТС-22525-11-60-А-48 дугаартай буцалтгүй тусламжийн хүрээнд гүйцэтгэв. Үндэсний мэдээллийн аюулгүй байдал, гео орон зайн технологийн консорциум (УМАБГОЗТК) нь Техасын Коллин Коллеж, Вашингтоны Бэллэвү Коллеж, Массачусетсийн Бункер Хилл Олон Нийтийн Коллеж, Техасын Дел Мар Коллеж, Иллинойсийн Морайне Валлэй Олон Нийтийн Коллеж, Аризонагийн Рио Саладо Коллежийг нэгтгэл юм. Энэхүү мэдээлэл нь “Creative Commons Attribution 3.0” Бүтээгчийн энгийн эх сурвалжийн хагас лицензийн дагуу зөвшөөрөгдсөн. Лицензийг https://creativecommons.org/licenses/by/3.0/ холбоосоос үзэх эсвэл 444 Кастро гудамж, Суйтэ 900, Моунтайн Вью, Калифорниа, 94041, АНУ хаягт байрлах Creative Commons компани руу захидал